



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/18/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: Б.Ганцэцэг Утас: 70512123
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар .....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	14
5.1 Төлбөрийн акт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5.2 Зөвлөмж .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	15

#### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Н.БАДРАХЦОГ ТАНАА

2023.02.17 № 41  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны 06-р сард Аймаг, Сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дахин сонгууль болж улсын төсвөөс 3,908.4 мянган төгрөг зарцуулсан.

### Аудитын гол асуудал

Улсын бүртгэлийн Ерөнхий газраас 21 аймагт нэгдсэн журмаар 19.9 сая төгрөгийн үнэ бүхий архивын нягтруулгын шүүгээ худалдан авч 2023 оны 1-р улиралд угсарч суурилуулж дуусахаар гэрээ байгуулсантай холбоотой авлагаар бүртгэж тайлагнасан байна. Тус байгууллагын үр дүнгийн тайлангаар нийт зардал 438.1 сая төгрөг болж өмнөх оноос 74.1 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь 2021 онд Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулагдсантай холбоотойгоор өмнөх оны зардлыг өсгөсөн байна.

### Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 4 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилт "Хангалттай" үнэлэгдсэн байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>35,316,914.00</u></b>	<b><u>40,581,161.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	52,000.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	52,000.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	52,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	00.00	52,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	19,952,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	19,952,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	19,952,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	35,316,914.00	20,577,161.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	10,139,544.00	7,300,821.00
35110	Тусгай зориулалттай материал	10,139,544.00	7,300,821.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,993,630.00	5,491,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	23,183,740.00	7,784,940.00
35410	Бичиг хэргийн материал	2,928,940.00	2,538,540.00
35420	Аж ахуйн материал	8,815,800.00	3,957,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	289,000.00	289,000.00
35470	Бусад хангамжийн материал	11,150,000.00	1,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>176,453,608.03</u></b>	<b><u>149,171,615.61</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	176,453,608.03	149,171,615.61
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	166,937,807.92	137,519,615.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	20,852,370.00	20,852,370.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,502,284.40	-3,336,379.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171,066,216.00	184,733,258.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,101,435.98	-65,933,011.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,243,130.00	14,243,130.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,620,187.70	-13,039,751.83
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,515,800.11	11,652,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,652,000.00	11,652,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,136,199.89	00.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>211,770,522.03</u></b>	<b><u>189,752,776.61</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>52,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	52,000.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	00.00	52,000.00
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	00.00	52,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>211,770,522.03</u></b>	<b><u>189,700,776.61</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	211,770,522.03	189,700,776.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,652,000.00	11,652,000.00
51101	Өмч: - төрийн	11,652,000.00	11,652,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	188,195,100.13	166,125,354.71
51210	Өмнөх үеийн үр дүн	188,195,100.13	190,331,300.02
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-24,205,945.31

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,923,421.90	11,923,421.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>211,770,522.03</u></b>	<b><u>189,752,776.61</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>644,441,083.87</b>	<b>420,419,306.53</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>180,298,183.87</b>	<b>16,549,906.53</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	180,298,183.87	16,549,906.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	180,298,183.87	16,549,906.53
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	180,298,183.87	16,549,906.53
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>464,142,900.00</b>	<b>403,869,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	398,935,200.00	399,961,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	398,935,200.00	399,961,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	65,207,700.00	3,908,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,707,700.00	3,908,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>512,321,702.99</b>	<b>438,125,251.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>512,321,702.99</b>	<b>438,125,251.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	511,295,811.31	436,076,222.34
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	332,920,418.69	308,276,300.00
210101	Үндсэн цалин	234,645,861.26	242,575,541.15
210102	Нэмэгдэл	86,969,957.43	57,380,783.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,304,600.00	6,303,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	2,016,975.46
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,105,545.63	40,611,160.50
210201	Тэтгэврийн даатгал	30,495,790.30	28,220,204.74
210202	Тэтгэмжийн даатгал	3,175,449.09	3,097,739.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,540,419.68	2,478,191.29
210204	Ажилгүйдлийн даатгал	626,689.98	619,548.04
210205	Эрүүл мэндийн даатгал	6,267,196.58	6,195,477.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,318,382.00	11,728,130.00
210301	Гэрэл, цахилгаан	350,000.00	868,000.00
210302	Түлш, халаалт	2,969,050.00	7,265,670.00
210303	Цэвэр, бохир ус	149,332.00	264,160.00
210304	Байрны түрээс	1,850,000.00	3,330,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,435,290.90	21,276,600.00
210401	Бичиг хэрэг	5,667,568.90	6,714,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,065,500.00	2,301,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,960,312.00	1,770,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,089,000.00	10,338,400.00
210408	Бараа материал акталсны зардал	1,652,910.00	102,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,134,000.00	1,011,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	189,000.00	00.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	220,000.00	557,000.00
210604	Урсгал засвар	1,725,000.00	454,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>535,500.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	535,500.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,515,276.75</b>	<b>9,123,078.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,141,000.00	2,470,980.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,374,276.75	6,652,098.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>82,331,397.34</b>	<b>44,049,853.84</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,707,700.00	3,908,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	324,000.00	350,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,299,697.34	39,791,453.84
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,025,891.68</b>	<b>2,049,029.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>250,000.00</b>	<b>350,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	350,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>775,891.68</b>	<b>1,699,029.50</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	775,891.68	1,699,029.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>132,119,380.88</u></b>	<b><u>-17,705,945.31</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>187,000.00</b>	<b>6,500,000.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	187,000.00	6,500,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-187,000.00</b>	<b>-6,500,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>131,932,380.88</u></b>	<b><u>-24,205,945.31</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>605,173,577.40</u></b>	<b><u>507,451,091.98</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>141,030,677.40</b>	<b>103,581,691.98</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	141,030,677.40	103,581,691.98
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	141,030,677.40	103,581,691.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	141,030,677.40	103,581,691.98
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>464,142,900.00</b>	<b>403,869,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	398,935,200.00	399,961,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	398,935,200.00	399,961,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	65,207,700.00	3,908,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,707,700.00	3,908,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>605,174,577.40</u></b>	<b><u>506,249,091.98</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>605,174,577.40</b>	<b>506,249,091.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>463,117,008.32</b>	<b>400,670,370.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	332,920,418.69	308,276,300.00
210101	Үндсэн цалин	234,645,861.26	242,575,541.15

210102	Нэмэгдэл	86,969,957.43	57,380,783.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,304,600.00	6,303,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	2,016,975.46
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,105,545.63</b>	<b>40,611,160.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,495,790.30	28,220,204.74
210202	Тэтгэмжийн даатгал	3,175,449.09	3,097,739.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,540,419.68	2,478,191.29
210204	Ажилгүйдлийн даатгал	626,689.98	619,548.04
210205	Эрүүл мэндийн даатгал	6,267,196.58	6,195,477.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>5,318,382.00</b>	<b>11,728,130.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	350,000.00	868,000.00
210302	Түлш, халаалт	2,969,050.00	7,265,670.00
210303	Цэвэр, бохир ус	149,332.00	264,160.00
210304	Байрны түрээс	1,850,000.00	3,330,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,189,462.00</b>	<b>11,082,300.00</b>
210401	Бичиг хэрэг	3,903,600.00	6,109,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,065,500.00	2,301,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,960,312.00	1,770,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,260,050.00	852,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,875,000.00</b>	<b>22,243,100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	630,000.00	450,000.00
210602	Тавилга	00.00	19,952,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	520,000.00	587,000.00
210604	Урсгал засвар	2,725,000.00	1,254,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>535,500.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	535,500.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,141,000.00</b>	<b>2,470,980.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,141,000.00	2,001,980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	469,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>62,031,700.00</b>	<b>4,258,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,707,700.00	3,908,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	324,000.00	350,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>142,057,569.08</b>	<b>105,578,721.48</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>250,000.00</b>	<b>350,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	350,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>141,807,569.08</b>	<b>105,228,721.48</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	775,891.68	1,793,049.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>-1,000.00</u></b>	<b><u>1,202,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>1,150,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>1,150,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>1,150,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,150,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>-1,150,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-1,000.00</b>	<b>52,000.00</b>

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,000.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	52,000.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний ноц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,652,000.00	11,923,421.90	50,307,379.23	00.00	73,882,801.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	7,696,738.49	00.00	7,696,738.49
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,652,000.00	11,923,421.90	58,004,117.72	00.00	81,579,539.62
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,622,112.76	00.00	-4,622,112.76
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,652,000.00	11,923,421.90	188,195,100.13	00.00	211,770,522.03
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,652,000.00	11,923,421.90	188,195,100.13	00.00	211,770,522.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,136,199.89	00.00	2,136,199.89
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,652,000.00	11,923,421.90	190,331,300.02	00.00	213,906,721.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-24,205,945.31	00.00	-24,205,945.31
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,652,000.00	11,923,421.90	166,125,354.71	00.00	189,700,776.61

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	399,961,000.00	398,261,970.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399,961,000.00	398,261,970.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,160,200.00	397,911,970.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,276,300.00	308,276,300.00
210101	Үндсэн цалин	252,229,400.00	242,575,541.15
210102	Нэмэгдэл	46,554,900.00	57,380,783.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,392,000.00	6,303,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,100,000.00	2,016,975.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,659,600.00	40,611,160.50
210201	Тэтгэврийн даатгал	28,328,500.00	28,220,204.74
210202	Тэтгэмжийн даатгал	3,332,800.00	3,097,739.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,666,200.00	2,478,191.29
210204	Ажилгүйдлийн даатгал	666,600.00	619,548.04
210205	Эрүүл мэндийн даатгал	6,665,500.00	6,195,477.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,735,700.00	11,728,130.00
210301	Гэрэл, цахилгаан	868,000.00	868,000.00
210302	Түлш, халаалт	6,141,800.00	7,265,670.00
210303	Цэвэр, бохир ус	285,500.00	264,160.00
210304	Байрны түрээс	4,440,400.00	3,330,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,100,000.00	11,082,300.00
210401	Бичиг хэрэг	6,137,800.00	6,109,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,303,400.00	2,301,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,770,300.00	1,770,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,700.00	50,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	837,800.00	852,000.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,522,300.00	23,393,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,634,600.00	1,600,000.00
210602	Тавилга	20,000,000.00	19,952,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	588,300.00	587,000.00
210604	Урсгал засвар	1,299,400.00	1,254,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,488,500.00	2,470,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,003,700.00	2,001,980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	469,000.00	469,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,400.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	8,400.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	377800.00	350000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	377,800.00	350,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	800800.00	350000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	800,800.00	350,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,800.00	350,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	399,961,000.00	398,261,970.50
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	399,961,000.00	398,261,970.50
131001	Улсын төсвөөс санхүүжих	399,961,000.00	398,261,970.50
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	28.00	28.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>3,908,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>3,908,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		3,908,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		3908400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,908,400.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		3908400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		3,908,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,908,400.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс “Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэх, Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулахад оршино” эрхэм зорилгын хүрээнд иргэний бүртгэл, эд хөрөнгийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон УСНББОУС-тай нийцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 05.29-ны өдрийн А/87 тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,017.7 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	52.0	52.0
Авлага	0	19,952.0	19,952.0
Бараа материал	35,316.9	20,577.2	-14,739.7
Үндсэн хөрөнгө	176,453.6	149,171.6	-27,282.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>211,770.5</b>	<b>189,752.7</b>	<b>-22,017.7</b>
Өр төлбөр	-	52.0	52.0
Засгийн газрын хувь оролцоо	211,770.5	189,700.7	-22,069.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө /Өмчийн дүн/</b>	<b>211,770.5</b>	<b>189,752.7</b>	<b>-22,017.7</b>

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь арилжааны банкинд байрших орлогын дансны үлдэгдэл байна.
- Авлага данс 19,952.0 мянган төгрөгөөр өссөн нь Улсын бүртгэлийн Ерөнхий газраас 21 аймагт нэгдсэн журмаар 19,952.0 мянган төгрөгийн үнэ бүхий архивын нягтруулгын шүүгээ худалдан авч худалдах, худалдан авах гэрээгээр 2023 оны 1-р улиралд гүйцэтгэж дуусахаар гэрээ байгуулсан тул авлагаар бүртгэж тайлагнасан.
- Бараа материал данс 14,739.7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь 7,326.6 сая төгрөгийн материал УБЕГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан, мөн үндсэн хөрөнгийн шинжтэй 6,500.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлсэн, ковидтой холбоотой үлдэгдлээр байсан гар ариутгах санитол, нэг удаагийн маск зэргийг зарлагадсан нь нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө данс 37,345.0 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэл гол нөлөө үзүүлсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 490,357.5 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 399,961.0 мянган төгрөг батлагдсан байна. Энэ нь цалин хөлсийг 2022 онд нэмэхээр төсөвлөсөн боловч нэмэгдээгүй, мөн хичээл үйлдвэрлэлийн зардалд цахим гарын үсэгтэй холбоотой сургалт сурталчилгаа зохион байгуулахаар төлөвлөсөн, ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж, урамшуулал зэргийг Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан хассан нь нөлөөлсөн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 399,961.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 398,261.9 мянган төгрөгийн зардал гарч 1,699.0 мянган төгрөг төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 398,261.9 мянган төгрөг буюу 99.6 хувьтай зарцуулсан байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71406 80101- Үндсэн үйл ажиллагаа	399,160.2	397,911.9	1,248.2	99.6%
2	70406 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	800.8	350.0	450.8	43.7%
<b>НИЙТ</b>		<b>399,961.0</b>	<b>398,261.90</b>	<b>1,699.0</b>	<b>99.6</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар УБЕГ-аас сонгууль зохион байгуулахтай холбоотой орон нутгийн нөхөн сонгуулийн зардалд нийт 3,908.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 100 хувь үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл бараа үйлчилгээний бусад зардалд 3,908.7 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрх ийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ганцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 54 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 438,125.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,571.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага нь албан томилолтын зардал болон ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал зэргийг хасаж баталсан арга хэмжээ авч ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>1</sup> заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд бүрэн гүйцэт, хуулийн хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгсөн.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,130.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Оффис хөшиг, халуун хүйтэн тенн худалдан авсан боловч бараа материалын дансаар дамжуулан бүртгэхгүйгээр шууд зардалд илэрхийлснийг залруулсан.

<sup>1</sup> бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

## 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр түлш, халаалтын зардлаас байрны түрээсийн зардал, шуудан холбоо, БҮТЭЗ-ийн зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний зардал, шатахууны зардлаас томилолтын зардалд гаргасан зөрчил илэрлээ.

#### Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын хавсралт дахь эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, зохицуулалт хийх тохиолдолд Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал журмыг баримталж ажиллах.

### 2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 13 ширхэг хөрөнгө бүртгэгдсэн байна.

#### Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж, хөрөнгийг дахин үнэлэх болон актлах саналуудыг эрх байгууллагад хүргүүлэх.

### 3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Өмч, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрийг шилэн дансны цахим системд байршуулаагүй.

#### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор шилэн дансны цахим системд мэдээлж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл								/мянган төгрөг/				
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		

Түлш, халаалтын зардлаас байрны түрээсийн зардалд, шуудан холбоо, БҮТЭЗ-ийн зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний зардалд, шатахууны зардлаас томилолтын зардалд гаргасан нь урсгал зардлыг эдийн засгийн ангилалын дагуу тайлагнаагүй, зориулалтын дагуу зарцуулаагүй байна.	1	-			1	-			1	-	1	-
Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 88 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна	1	-			1	-			1	-	1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>			<b>2</b>	<b>-</b>			<b>2</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
www.shilendans.gov.mn Өмч, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрийг тухай бүр байршуулаагүй	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>					<b>1</b>	<b>0</b>